## VII. Цаашдын зорилго

Хөгжиж буй орнууд МХТ-ийн ач холбогдлыг ихээр ухаарч байгаа бөгөөд эдгээр орнуудад тоон ялгааг арилгахад засгийн газар хувийн сектортой хамтран ажиллах хэрэгтэй байгаа юм. МХТ-ийн хувьсгал нь түүхийн чиг хандлагыг өөрчилж байгаа нь гарцаагүй бөгөөд хөгжиж буй орнууд дижитал хувьсгалыг явуулахад нь тус болох мэдээлэлтэй байж, зохих бодлогыг боловсруулах хэрэгтэй байна. Мэдээллийн эдийн засаг, нийгэм хийгээд засгийн газрын талаарх үндсэн ойлголтуудын тухай энэхүү цуврал нь Ази Номхон далайн бүс нутаг дахь хөгжиж буй орнуудын бодлого боловсруулагчдад мэдээллийн зуунд хэрэглэгдэж байгаа нэр томьёо, тодорхойлолт, чиг хандлага, мөн тулгамдаад асуудлын талаар ойлголт өгөх зорилготой билээ

Энэхүү цувралд орсон номуудыг дурьдвал

- Nets, Webs and Information Infrastructure
- E-commerce and E-business
- Legal and Regulatory Issues in the Information Economy
- E-Government
- ICT and Education
- Genes and, Technology and Policy: An Introduction to Biotechnology

Энэ цуврал номууд хөгжиж буй орнуудын мэдээллийн эринд алхан орохоор гаргаж буй хүчин чармайлтад нь түлхэц болж өгнө гэдэгт бид итгэлтэй байгаа юм

Мэдээллийн хувьсгалын талаар олон зүйлүүд хэвлэгдэн гарч олон ч санаачилгууд амжилттай хэрэгжсэн ч бас зарим санаа санаачилгыг дэмжин чиглүүлж өгөх шаардлагатай байна. Тоон хуваагдал, даяарчлал, зэрэг нь улс төр, эдийн засаг, нийгмийн бүтэц болон соёлд ихээр нөлөөлж байгаа бөгөөд үүнд мэдээлэл нь гол үүрэгтэй юм. Иймээс мэдээлэл хөгжил дэвшлийн эрин зуунд байр сууриа олж авахын тулд тоон хуваагдал болон даяарчлалд анхаарлаа төвлөрүүлэх нь зүйтэй юм